



**“ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ” ТӨҮГ-ЫН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС
ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ
ХИЙСЭН АЖЛЫН ТОВЧ ТАЙЛАН**

2025.07.30

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын зорилго

Зам, тээврийн хөгжлийн төв ТӨҮГ /ЗТХТ/-ын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үнэлэлт, дүгнэлт өгөх, цаашид анхаарч ажиллах асуудлын талаар санал, зөвлөмж боловсруулах замаар яамны удирдлага, албан тушаалтныг холбогдох мэдээллээр хангах зорилгоор энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг гүйцэтгэлээ.

Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг дүгнэхдээ Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Хяналт-шинжилгээ хийх журам”, “Үнэлгээ хийх журам”, “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам”, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021 оны А/87 дугаар тушаалаар баталсан “Зам, тээврийн хөгжлийн яам болон харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ыг үндэслэл болгосон.

Хоёр. Танилцуулга

ЗТХТ ТӨҮГ-ын 2025 оны эхний хагас жилийн үйл ажиллагааг Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, Сайдын тушаалын биелэлт, Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ, Ил тод байдлын үнэлгээ гэсэн 5 үзүүлэлтээр дүгнэсэн бөгөөд нэгдсэн дүнгээр **84.4%**-тай байна.

Яамнаас Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд туссан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөө баталж, холбогдох харьяа байгууллагуудыг хэрэгжүүлэгч байгууллагаар тогтоогоогүй тул эдгээр бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг үнэлгээнд оруулаагүй болно. Эдгээрийг тус тусад нь авч үзвэл:

2.1. ЗТХТ ТӨҮГ-ын 2025 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан ажил, үйлчилгээний хэрэгжилтийн байдлыг доорх хүснэгтэд үзүүлэв.

Нийт заалт	Үүнээс						Хугацаа болоогүй	Биелэлтийн хувь
	100%	90%	70%	50%	30%	0%		
84	36	15	13	8	9	1	2	79.6%

2.2. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн явцыг дүгнэвэл:

Нийт заалт	Үүнээс				Биелэлтийн хувь
	Хэрэгжсэн	Хэрэгжээгүй	Хугацаа болоогүй	Хүчингүй болсон	
5	5	-	-	-	100%

2.3. Сайдын тушаалаар өгсөн үүрэг даалгаврын биелэлт:

Нийт заалт	Үүнээс				Биелэлтийн хувь
	Хэрэгжсэн	Хэрэгжээгүй	Хугацаа болоогүй	Хүчингүй болсон	
7	5	2	-	-	71.4%

**2.4. Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ:**

Мэдээлэл		Нийт заалт	Үүнээс					Биелэлтийн хувь
			100%	70%	30%	0%	Хугацаа болоогүй	
ЗТХТ	төсөв, гүйцэтгэл	9	6	-	-	-	3	100%
	хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт	5	4	-	-	-	1	100%
	бусад	8	7	-	-	-	1	100%
Нийт		22	17	-	-	-	5	100%

2.5. Ил тод, нээлттэй байдлын шалгуур үзүүлэлтүүдийн үнэлгээ:

Мэдээлэл		Нийт заалт	Үүнээс					Биелэлтийн хувь
			100%	70%	50%	30%	0%	
Нийт		45	22	1	1	3	7	70.9%

Гурав. Үнэлэлт, дүгнэлт**Төлөвлөлтийн байдал:**

ЗТХТ ТӨҮГ нь 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулахдаа ХШҮДАГ-аас өгсөн зөвлөмжийн дагуу арга хэмжээнүүдийг хариуцах хэлтэс, албадыг нэр заан тусгаж, хэрэгжүүлэх арга хэмжээний хүрэх түвшнийг улирлаар хуваан яамны төлөвлөгөөтэй уялдуулан төлөвлөсөн байна.

Мөн Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор “Хяналт-шинжилгээ хийх журам”, “Үнэлгээ хийх журам”, “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам” шинэчлэн батлагдсантай холбоотой байгууллагуудын Гүйцэтгэлийн төлөвлөгөөний суурь болон зорилтот түвшинг тоо, хувиар илэрхийлж болохуйцаар шалгуур үзүүлэлтийг тодорхойлж, өөрчлөлт оруулах шаардлагатай байна.

Хэрэгжилтийн байдал:

1) ЗТХТ ТӨҮГ-ын 2025 оны эхний хагас жилийн үйл ажиллагааг Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, Сайд-ын тушаалын биелэлт, Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ, Ил тод байдлын үнэлгээ гэсэн 5 үзүүлэлтээр дүгнэсэн бөгөөд нэгдсэн дүнгээр **84,4%**-тай байна.

2) 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан 84 арга хэмжээний хэрэгжилт 79,6% байна. Үүнээс 62% нь эхний хагас жилд хүрэх түвшиндээ бүрэн хүрсэн болон хүрэх шатандаа, 38% нь төлөвлөсөн үр дүндээ хүрээгүй буюу хэрэгжилт хангалтгүй байна.

3) Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг зорилтуудаар нь авч үзвэл:

Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжилтийн хувь
Зорилт 1: Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих авто зам, гүүрийн барилгын ажилд техник технологийн хяналтын зөвлөх үйлчилгээг үзүүлнэ.	22	89%
Зорилт 2: Авто замын барилга угсралт, засвар арчлалтын материалд сорил, шинжилгээг хийж, хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлнэ.	7	82.8%
Зорилт 3: Олон улс, улсын чанартай 14,921 км авто замын арчлалт, засварын ажлыг зохион байгуулж, хяналтын зөвлөх үйлчилгээг хэрэгжүүлнэ.	8	33.7%



ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ

Зорилт 4: Захиргааны болон хүний нөөцийн манлайллыг хэрэгжүүлж, эрхзүйн зохицуулалтыг ханган санхүү, хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг зохицуулж, хэрэгжүүлнэ.	19	82.7%
Зорилт 5: Бодлогын хэрэгжилт, зураг төслийн магадлал, стандарт, норм нормативыг шинэчлэн сайжруулж, боловсронгуй болгоно.	6	81.7%
Зорилт 6: Төлбөр авах үйл ажиллагааг цахимжуулж, түргэн шуурхай байдлыг хангуулна.	14	73.5%
Зорилт 7: Эрдэм шинжилгээ, судалгааг хөгжүүлэх, инновац нэвтрүүлэх, хамтын ажиллагааг өргөжүүлнэ.	8	90%
НИЙТ ДҮН	84	79.6%

Эдгээр зорилтуудаас “Олон улс, улсын чанартай 14,921 км авто замын арчлалт, засварын ажлыг зохион байгуулж, хяналтын зөвлөх үйлчилгээг хэрэгжүүлнэ” зорилт хамгийн бага буюу 33.7%-тай үнэлэгдсэн байна.

Дөрөв. Санал, зөвлөмж

1. Олон улс, улсын чанартай авто замын арчлалт, засварын ажлыг зохион байгуулж, хяналтын зөвлөх үйлчилгээг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд төлөвлөсөн ажлуудыг эрчимжүүлж, хугацаанд нь дуусгах;

2. Норм, нормативын сангийн төлөвлөлтийг сайжруулж, тухайн онд хэрэгжих ажил үйлчилгээг яамны Шинжлэх ухаан, технологийн зөвлөлөөр хэлэлцүүлж, Хяналтын зөвлөлд хэрэгжилтийг тайлагнаж ажиллах.

3. Авто замын барилга, шинэчлэлт, засвар, арчлалтын ажлын гүйцэтгэлийг хянан баталгаажуулах журмыг шинэчлэн боловсруулж, Зам, тээврийн сайдаар батлуулж мөрдөх;

4. Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд хийгдсэн аудит шалгалтын зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлан хэрэгжүүлж ажиллах, санхүүгийн сахилга батыг сайжруулах, алдаа, дутагдал гаргахгүй байхад анхаарч хяналтыг сайжруулах;

5. Засгийн газрын 2022 оны 352 дугаар тогтоолоор батлагдсан “Нээлттэй мэдээллийг ил тод байлгах, болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам”-ын хавсралтаар Нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээг 5 хэсгийн 98 нээлттэй мэдээллээс өөрт хамаарах асуудлыг shilen.gov.mn сайтад тайлагнаж ажиллахаар шийдвэрлэсний дагуу тус сайтад бүртгүүлэн холбогдох мэдээллийг тогтоосон хугацаанд нь байршуулах;

6. Хяналт-шинжилгээний журамд өөрчлөлт орсонтой холбогдуулан Гүйцэтгэлийн төлөвлөгөөг шинэчлэхдээ дараах зүйлсийн анхаарах. Үүнд:

➤ Суурь болон зорилтот түвшинг тоо, хувиар илэрхийлж болохуйцаар шалгуур үзүүлэлтийг тодорхойлж, улирал бүрээр хүрэх боломжтой, бодитойгоор төлөвлөх.

➤ Ил тод байдлыг хангах, шилэн дансны тайлан, санхүүгийн тайланг хугацаанд нь мэдээлэх, ХАБЭА-ийн ажлууд зэрэг байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд зорилт болгон дээр давхацуулан тусгасан ажлуудыг нэгтгэх;

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР